

БАЯНХОНГОР -2010 ОНЦЛОХ 10



Баянхонгор аймгийн хэмжээнд 2010 оныг “Үйлдвэржилтийг нэмэгдүүлэх жил” болгон зарлаж ажилласан.

1. 2010 онд Жижиг дундйлдвэр хөгжүүлэх чиглэлээр 73 төсөлд 885,9 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосноос нийтдээ 360 гаруй ажлын байр хадгалагдаж 28 үйлдвэр үйлчилгээний салбар нэмэгдэж 200 орчим ажлын байр шинээр бий болсон.

2. Баянхонгор аймгийн “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” 2021 он хүртлэх хөтөлбөрийг аймгийн Засаг даргын 2010 оны 128 дугаар захирамжаар батлан хэрэгжүүлснээр 1882 хүн ажилтай болсны 1043 хүн нь байнгын ажлын байртай болж, амьжиргаа нь дээшилсэн байна.



3. Хөрөнгө оруулалтуудыг нэмэгдүүлэх.

Аймгийн хэмжээнд 2010 онд улсын болон орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөрөөр барилга байгууламж шинээр барих болон их засварын ажилд 9.1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлууд хийгдлээ. Улсын төсвийн хөрөнгөөр 5.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалттай 26 барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авч 300,6 сая төгрөгийн автомашин, компьютер тоног төхөөрөмжийг сумдад нийлүүллээ.

Баянхонгор сумын 7-р багт 75 үүхдийн цэцэрлэг, эрүүл мэндийн салбарт: 50 ортой төрөх эмнэлэг, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асаргаа сувилгааны төв баригдаж, Баянцагаан, Бууцагаан сумын соёлын төвийг шинээр барих ажил эхлээд байна.

“Цахим эмнэлэг” өгтөлбөр амжилттай хэрэгжиж сүлжээнд холбогдсноор эмчилгээ оношлогоонд мэдээллийн технологийг ашиглах нөхцөл бүрдлээ.

Баянхонгор, Хүрээмарал, Баянбулаг сумдад цахилгаан дамжуулах агаарын шугамын дэд станц барих тендерт Эрчимийн ундраа ХХК, Электромонсеть ХХК компаниуд шалгарч ашигласнаар аймгийн бүх сумд гэрэл цахилгаантай болоод байна.



4. Эрчимжсэн хөдөө аж ахуйг хөгжүүлэх нь аймгийн тэргүүлэх зорилтуудын нэг.

А. 2010 онд 2492,0 тн өмс, 1194.5 тн хүнсний ногоо, 336.4 тн ногоон тэжээл хураан авсан нь ургац өмнөх жилээс 716.4 тн-оор нэмэгдэж аймгийн хүн амын хүнсний хэрэгцээт төмсний 73 хувь, хүнсний ногооны 27.7 хувийг хангалаа.

Б. Мал тооллогын дүнгээр 2010 онд аймгийн хэмжээгээр 1962,9 мянган толгой мал тоолуулснаас тэмээ 30,0 мянга, адуу 77,3 мянга, үхэр 101,5 мянга, хонь 543,8 мянга, ямаа 1213,3 мянган толгой тоологдож өнгөрсөн оныхноо с 26,9 хувь буюу 721,7 мянган толгойгоор буурсанөвөлжилтийн бэлтгэл хангах ажлыг сайн зохион байгуулсны дүнд харьцангуй бага хохирол хүлээсэн.





5. Боловролын салбарт:

Баянхонгор аймгийн Өлзийт сумын уугуул Монгол Улсын төрийн шагналт, гавъяат багш, академич, хэл шинжлэлийн ухааны доктор, профессор Шадавын Лувсанвандангийн мэндэлсний 100 жилийн ойг улс орон даяар тэмдэглэх ажлын үрээнд монгол хэл бичгийн болон сэтгэх чадварын улсын олимпиадуудыг аймагтаа амжилттай зохион байгуулсан.



6. Батлан хамгаалах салбарын хөгжил манай аймагт.

Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр манай аймагт барилга-инженерийн Зэвсэгт хүчний 339 дүгээр анги шинээр байгуулагдсан нь өвхөн өөрийн аймгийн төдийгүй баруун бүсийн аймгуудын бүтээн байгуулалтад цэргийн албан хаагчдыг оролцуулах, ажлын байрыг нэмэгд, тус ангийг түшиглэн дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүн, орон нутгийн цэргийн сургалтыг явуулах боломж бүрдлээ.



7. Баян-Өндөр сумын нутагт Амарбуяантийн хийд анх үүсэн байгуулагдсаны 315 жил, дахин сэргэсний 20 жил, Гүшири хувилгаан Данзинчойжийнямааг хүндэтгэн сэнтийд нь залах ёслолыг өндөр түвшинд зохион байгуулсан сүсэгтэн олны хүндэтгэл хүлээсэн ажил болсон.



8. "Хонгор -1000" орон сууцны хороолол барих газрын байршлыг 3-р багийн нутаг дэвсгэрт 4-р сургуулийн орчимд сонгож байршлын зургийг гаргаж, төлөвлөлтийн ажлыг хийж Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа "100 мянган айлын орон сууц" хөтөлбөр төслийн хүрээнд /2010-2015 онд/ 440 хүүхдийн сургууль, 50 хүүхдийн цэцэрлэг, 120 хүнд үйлчлэх хүчин чадалтай ахуйн үйлчилгээний төв, 300 суралцагчтай МСҮТөв, өдөрт 30 хүнд үзлэг хийх хүчин

чадалтай өрхийн эмнэлэг барихаар төлөвлөгдсний дагуу барилга байгууламжийн байршлын зураг гаргаж 200 айлын орон сууц, барих ажил эхлээд байна.



9. Шинэжинст сумын Хотгорын 99 сая тонн-ын нөөцтэй ордыг үшиглэн говийн бүсэд дулааны цахилгаан станц, нүүрс угаах болон коксны үйлдвэр барих саналууд ирж Шинэжинст сумаасӨмнөговь ай мгийн Гурвантэс сум хүртэл 314 км хатуу хучилттай замын зураг төсөв хийгдэн замын ажлыг 6 дугаар сарын 01-нээс эхлэхээр төлөвлөн ажиллаж байна.



10. Амралт, аялал жуулчлалын 3 бүс цогцолборын үйл ажиллагаа амжилттай хэрэгжиж байна. Тус аймаг нь “Баянхонгор аймагт аялал жуулчлал хөгжүүлэх мастер төлөвлөгөө боловсруулж, Баянхонгор хотыг аялал жуулчлалын хот байхаар тодорхойлон 2006 оны 12-р сард аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 153 дугаар тогтоол гарч “Амралт, аялал жуулчлалын 3 бүс цогцолбор”-ын бүтээн байгуулалтын ажил эхэлсэн байна. Хамгийн гол нь Баянхонгор аймаг нь 3 бүсийн нутаг гэдгээрээ алдартай бөгөөд Баянхонгор аймаг юугаараа бусдаас онцлог юм бэ гэдгийг энэ цогцолбортоо тусгах, сурталчлах, үүгээр дамжуулан дотоод гадаадын жуулчдыг татах цогцолбор

байхаар төлөвлөгдсөн. Одоогоор гол цогцолборын бүтээн байгуулалтын ажил нилээд амжилттай хэрэгжиж байна. 2009-2010 онд нийт 140 гаруй сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэн “Динозаврын Парк”-ийн хашаа, динозаврын цогцолбор хөшөөнүүд болон усан оргилуурын цогцолбор 70-80%-тай ашиглалтанд ороод байна. 2011 оны байдлаар 80 гаруй сая төгрөгийн хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтад зориулагдан ороод байна.

